

Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Бодлого

Эцэг эх болон асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах нь сурагчийн сайн сайхан байдал, сургууль дээрх оролцоо болон сурлагын үр дүнд нөлөөлдөг. NSW мужийн улсын сургуулиуд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл болон арьс өнгөөр ялгаварласан аливаа зан авирыг хүлээн зөвшөөрөхгүй.

Энэхүү бодлого нь юуны тухай вэ?

Энэхүү [Anti-Racism Policy](#) (Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Бодлого) нь сургуулийн орчинд хүндлэл, эв найрамдлыг сурталчилдаг. Энэ нь хэл, соёл, шашин шүтлэгээс үл хамааран сурч боловсрох боломжийг бүх сурагчдад шударга хүртээмжтэй байлгахыг зорьдог. Энэхүү бодлого нь:

- Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл нь уугуул нутгийн болон Торрес Стрэйт арлын иргэдэд хэрхэн нөлөөлдөг тухай танин ухамсарладаг
- сургуулиудыг бүх сурагчдаасаа өндөр хүлээлттэй байж, сурагчид оюуны бүрэн чадамжиндаа хүрэхэд нь хэл, соёл болон шашин шүтлэгээс шалтгаалсан аливаа саадгүй байх боломжоор хангадаг.
- сургуулийн хүрээлэл дэх бүх ажилтан ард иргэд өөрсдийн зан авирыг эргэцүүлж, тэдний аливаа үйлдэл нь бусдыг арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан байдалд хүргэхгүй байхыг шаарддаг.
- бүх ажилтнуудыг сургалтанд бүрэн хамрагдахыг шаарддаг ба ингэснээр арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдлаас сэргийлэхэд өөрсдийн үүрэг хариуцлагаа ойлгож ухамсарлах юм.
- сургууль бүр тусгай сургагдсан Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Холбогдох Ажилтантай байх шаардлага тавьдаг.

Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Холбогдох Ажилтан гэж хэн бэ?

Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Холбогдох Ажилтан (Anti-Racism Contact Officer (ARCO)) бол сургууль дээр арьс өнгөөр ялгаварлан гадуурхлын тухай боловсрол олгоход туслах үүрэгтэй тухайн сургуулийн захирал томилсон багш юм. ARCO нь сургуулийн захиралд дараах байдлаар тусладаг. Үүнд:

- ажилтнуудад арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл нь сурагчдын сурлага болон сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлдөг талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд нь дэмжих
- сурагчид болон сургуулийн ажилтнуудад арьс өнгөөр ялгаварлан гадуурхах тохиолдлыг харах эсвэл сонсох үед хэрхэн арга хэмжээ авах тухай зөвлөгөө өгөх
- сургууль арьс өнгөөр ялгаварлан гадуурхлыг таниулах ямар стратегийг хэрэгжүүлж болох тухай зөвлөх

ARCO нь эцэг эх, асран хамгаалагчид болон багш сурагчдад арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтай холбоотой мэдээллийг хэрхэн шийдвэрлэх үйл явцын тухай зөвлөгөө өгөхөөр сургагдсан байдаг. Хэрвээ хүсэлт гаргавал ARCO нь уг үйл явцад [support person or advocate](#) (туслах эсвэл дэмжин зөвлөх) үүрэгтэйгээр оролцох боломжтой.

Хэрвээ миний хүүхэд сургууль дээрээ арьс өнгөөр ялгаварлан гадуурхалд өртсөн бол би юу хийх ёстой вэ?

Хэрвээ таны хүүхэд сургууль дээрээ арьс өнгөөр ялгаварлан гадуурхалд өртсөн бол та хүүхэддээ өөрийн багшдаа эсвэл сургуулийн Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Холбогдох Ажилтанд мэдэгдэхийг зөвлөх ёстой ба эсвэл та хүүхдийнхээ өмнөөс мэдэгдэл гаргаж болно.

Сургууль дээрх арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтай холбоотой асуудлыг би хэрхэн мэдэгдэх вэ?

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтай холбоотой асуудлаар эцэг эх, асран хамгаалагчид, ажилтнууд болон сурагчид гэх мэт сургуулийн хүрээлэл дэх бүх гишүүд [a report](#) (мэдэгдэх) боломжтой. Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтай холбоотой мэдээллийг сургуулийн захирал, Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзэлтэй Тэмцэх Холбогдох Ажилтан эсвэл аль нэг ажилтанд өгч болно. Мэдээллийг биечлэн ирж, е-мэйл эсвэл утсаар, мөн түүнчлэн цахимаар тус яамны [feedback and complaint form](#) (санал гомдлын маягт)-ыг ашиглан өгч болно.

Цахим орчинд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах асуудал яах вэ?

Сургуульд хамааралтай цахим орчинд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдал тухайлбал сурагчид тодорхой нэг сурагч эсвэл соёлын бүлгийн эсрэг арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан аливаа үйлдлийг дээр заасны дагуу сургуульд мэдэгдэх ёстой. Цахим орчинд хэрхэн аюулгүй байх зөвлөгөөг [eSafety Commissioner website](#) (eSafety Комиссийн вэб хуудас) дээрх [Online safety](#) (Цахим аюулгүй байдал) хэсгээс харна уу.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг би хаанаас авах вэ?

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг [Anti-racism education](#) (Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлтэй тэмцэх тухай боловсрол) хэсгээс харна уу.

Орчуулагчийн туслалцаа

Хэрвээ танд сургуультай холбогдох эсвэл сургуулийн ажилтантай цаг товлоход орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй.

Операторт сургуулийнхаа утасны дугаарыг хэлснээр оператор сургууль руу залган холбох шугам дээр таны яриаг орчуулах орчуулагчийг холбох болно.

Хэрвээ танд сургуулийн ажилтантай уулзах уулзалтын үеэр орчуулагч хэрэгтэй бол сургуульд хүсэлтээ гаргаарай. Сургууль тухайн үеийн боломжоос хамааран биеэр ирэх, цахим, эсвэл утсан орчуулагчийг танд бэлэн байлгах болно. Орчуулгын үйлчилгээнд та ямар нэгэн төлбөр төлөхгүй.